



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 255

Улаанбаатар хот

Г Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны Г
266 дугаар тогтоолоор батлагдсан журамд
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.3, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.10 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор батлагдсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагааны журам” /цаашид “журам” гэх/-ын 3дугаар зүйлийн 3.1, 3.12, 3.22, 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулсугай:

1/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

“3.1. ТЗК-ийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багагүй байна.”

2/ 3 дугаар зүйлийн 12 дахь хэсэг:

“3.12. ТЗК-ийн үйл ажиллагааг ТУЗ удирдаж, хяналт тавих бөгөөд энэхүү үүргийг тодорхой гэрээний дагуу бусад этгээдээр гүйцэтгүүлж болно. ТУЗ-ийн гишүүн нь 3 болон түүнээс дээш байх ба нийт гишүүдийн олонхи нь Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12.8-д заасан шаардлага хангасан хараат бус этгээд байна.”

3/ 3 дугаар зүйлийн 22 дахь хэсэг:

“3.22. ТЗК нь дараах мэдээллийг дараа улирлын 20-ны өдрийн дотор, өөрчлөлт орсон бол ажлын 3 хоногийн дотор тухай бүр Хороо болон хөрөнгө оруулагчид цахим хэлбэрээр мэдээлэх бөгөөд хагас жилийн болон жилийн эцсийн мэдээллийг Хороонд бичгээр ирүүлнэ.”

4/ 4 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:

“4.8. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь Хорооноос тусгай зөвшөөрөл авсан этгээд байна. Хөрөнгө итгэмжлэн удирдагч нь энэхүү журмын 4.4.1, 4.4.4-т заасан шаардлага хангасан этгээд байх бөгөөд Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл болон дараахь шаардлага хангасан хуулийн этгээдэд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаастай холбоотой хөрөнгө итгэмжлэн удирдах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг Хороо олгоно.

4.8.1. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 20.1, 20.2-т заасан үйл ажиллагааг эрхлэхэд шаардлагатай хүний нөөцийн болон нягтлан бодох бүртгэл хийх, техникийн нөхцлөөр бүрэн хангагдсан байх;

000432

4.8.2. 3 болон түүнээс дээш тооны гишүүдээс бүрдсэн ТУЗ-тэй байх ба Компанийн тухай хуульд заасан шаардлага хангасан 1-ээс доошгүй ТУЗ-ийн хараат бус гишүүнтэй байх;

4.8.3. хөрөнгийн зохистой удирдлагыг гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөцийн болон мэдээллийн системийн туршлагатай байх;

4.8.4. орон тооны 1-ээс доошгүй олон улсын зэрэглэлтэй санхүүгийн мэргэжилтэн /CFA/-тэй байх;

4.8.5. Хорооноос шаардлагатай гэж үзсэн бусад.

2 дугаар зүйл. Журмын 2.6 дахь хэсгийн “Баталгаат үнэт цаас” гэснийг “Баталгаат үнэт цаасанд зээлийн зэрэглэл тогтоолгож болох бөгөөд баталгаат үнэт цаас” гэж, 2.8.6 дахь хэсгийн “ТЗК-ийн дүрмийн нотариатаар баталгуулсан хуулбар” гэснийг “ТЗК-ийн дүрэм” гэж, 2.8.15 дахь заалтын “түүний үнэлгээ” гэснийг “үнийн дүн” гэж, 2.9.10 дахь заалтын “хөрөнгийн багц /зээлийн багц/-ын алдагдал” гэснийг “тухайн хөрөнгийн хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээлийн талаарх мэдээлэл;” гэж, 2.9.16 дахь заалтын “үнэлэх зохицуулалт” гэснийг “үнэлэх эсэх талаарх мэдээлэл;” гэж, 3.13 дахь хэсгийн “хувь хүн байна.” гэснийг “хувь хүн байх бөгөөд өөр бусад ТЗК-ийн ТУЗ-ийн гишүүнээр давхар ажиллаж болно” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Журмын 2.2.2 дахь заалтын “өөрийн” гэснийг, 2.9.19 дэх заалтын “болон дотоод аудитын үйл ажиллагааны” гэснийг, 2.10.3 дахь заалтын “баталгаат үнэт цаас гаргагч нь төлбөрийн чадваргүй болох нь тогтоогдсон” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Журмын 2 дугаар зүйлийн 2.8.18 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.7.6 дахь заалтыг тус тус хассугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН